



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 8/40

Хэрлэн сум

Засварын ажлын
үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэн-Баянулаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Өнөрцэцэг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга: Н.Үнэнбат Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан ахлах
мэргэжилтэн

Гишүүд:
Б.Содбилэг Газрын харилцаа, барилга, хот
Х.Гонгор байгуулалтын газрын мэргэжилтэн
Д.Оюун Иргэний төлөөлөл
Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

